

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН 04 ДҮГЭЭР ХУРАЛ**

2020 оны 01 дүгээр сарын 18-ны өдрийн 10 цаг 45 минутад эхэлж, мөн өдрийн 19 цаг 14 минут хүртэл аймгийн Засаг даргын уулзалтын танхимд хийж, нийт 8 цаг 31 минут хуралдав.

дд	Хэлэлцсэн асуудал	Хурлаас гарсан шийдвэр
1	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2020 оны жилийн эцсийн тайлан хэлэлцүүлэх тухай.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн 2020 оны жилийн эцсийн тайлан хэлэлцүүлэхэд аймгийн хэмжээний өргөдөл гомдлын шийдвэрлэлт 98,5 хувьтай байгааг дэмжиж Засгийн газрын Хэрэг эрхлэх газарт хүргүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга Б.Ганболдод үүрэг болгов.
2	Ховд аймаг болон “МоЭнКо”ХХК хоорондын хамтран ажиллах гэрээний төсөл хэлэлцүүлэх тухай	Ховд аймаг болон “МоЭнКо”ХХК хоорондын хамтран ажиллах гэрээний төсөл хэлэлцүүлэх явцад гарсан саналыг тусгаж “МоЭнКо”ХХК-д гэрээний төслийг хүргүүлэхийг Аймгийн Засаг даргын орлогч Т.Жаргалсайхан, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга Б.Баярсүх нарт үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР